



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2013 оны 08 сарын 28 өдөр

Дугаар 289

Улаанбаатар хот

Г “Бурнавасан-Од ХХК-д “хонины ноос” Г  
гэсэн бараа, түүхий эдийн нэр төрлөөр  
тусгай зөвшөөрөл нэмж олгох” тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн 10.4, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын 2013 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн А/35 дугаар тушаал, Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 69 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн тусгай зөвшөөрлийн түр журам”-ын 1.3, 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Бурнавасан-Од ХХК-д “хонины ноос” гэсэн бараа, түүхий эдийн нэр төрлөөр Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлалын үйл ажиллагаа нэмж эрхлэхийг зөвшөөрсүгэй.

2. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000444